



**БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНЛИГ СУМД ХҮҮХДИЙН ТОГЛООМЫН ТАЛБА  
БАЙГУУЛАХ АЖЛЫН ЗАХИАЛАГЧ, ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХООРОНД БАЙГУУЛСАН  
ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ**

2022 оны 11 дүгээр сарын 30

Хатан суудал

Баянлиг сумд хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлын захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ(цаашид “Нэмэлт гэрээ” гэх)-г цаг үеийн нөхцөл байдал, тоглоомын талбай байгуулах талбайн нөхцөл байдлыг үндэслэн нэг талаас Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын Тамгын газар (цаашид “захиалагч” гэх ) түүнийг төлөөлж Засаг даргын тамгын газрын дарга Г.Мөнхсүх;

Нөгөө талаас “Түрүү алтан жолоо” ХХК-ийн захирал Б.Анхбаяр цаашид “гүйцэтгэгч” гэх нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү Нэмэлт гэрээг байгуулав.

**НЭГ. ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ,ӨӨРЧЛӨЛТ**

1.1 Баянлиг сумд хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлын захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний техникийн тодорхойлолтод тусгагдсаны дагуу 120 метрийн урттай, 2 метрийн өндөртэй хайс хашаатай байхыг хөл бөмбөгийн талбайн 40 метр хайсыг оруулан уг хийгдэх нийт 120 метр хайснаас 40 метр хайсыг хасч 6 хүүхдийн суудалтай эргэдэг тоглоом, хөлийн савлууур гэх 2 тоглоомыг хайсны үнийн дүнгийн зөрүүнд нэмэлтээр суурилуулах гэж өөрчлөв.

**ХОЁР. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ**

2.1 Энэхүү нэмэлт гэрээгээр нэмэлт өөрчлөлт оруулсан заалтуудаас бусад үндсэн гэрээний заалт хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

2.2 Энэхүү нэмэлт гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж тамга дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд үндсэн гэрээний салшгүй хэсэг байна.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

**Захиалагч:**

Хаяг:Баянхонгор аймаг Баянлиг сум  
Хатан суудал, 5-р баг

Засаг даргын Тамгын газрын дарга  
Г.Мөнхсүх

Утас:99918279

Гарын үсэг:

/Г.Мөнхсүх/  
(Тамга)

**Гүйцэтгэгч:**

Хаяг Баянхонгор аймаг Баянлиг сум  
Хатан суудал, 5-р баг

“Түрүү алтан жолоо” ХХК-ийн захирал  
Б.Анхбаяр

Утас: 99022600

Гарын үсэг:

(Тамга)



/Б.Анхбаяр/



БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНЛИГ СУМЫН ХҮҮХДИЙН  
ТОГЛООМЫН ТАЛБАЙ БАРИХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2023 оны 05 дугаар сарын 09

Хатансуудал

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын Тамгын газраас зарласан Хүүхдийн тоглоомын талбай барих, БХАБЛСЗДТГ/202206032/ дугаартай тендер шалгаруулатад 2022 оны 10 дугаар сарын 27- ны өдөр оролцож, 59,500,000, /Тавин есөн сая таван зуун мянган төгрөг /-ийн өртөгтэйгээр шалгарч тухайн ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан.

Гэрээний дагуу Баянхонгор аймаг Баянлиг сумын **3127834** тоот регистрийн дугаартай “Түрүү алтан жолоо” ХХК нь Хүүхдийн тоглоомын талбай барих ажлыг техникийн тодорхойлолт, зураг төсөвт тусгагдсаны дагуу хийж гүйцэтгэлээ.

1. Хөл бөмбөгийн талбайн зүүн талд 20 метрийн урттай, 2 метрын өндөртэй 2 тал хашаа, 40 метрийн урттай 2 метрийн өндөртэй 1 тал хашаа барьсан.



2023. 05.17-нд тусгагдсан.



2. Техникийн тодорхойлолтонд: Хашааны суурь бетон 20 см өргөнтэй, 30 см зузаантай, 20 см газарт суулгаж зугтах. Гүйцэтгэхдээ: Хашааны суурь бетоныг 27 см өргөнтэй, 30 см зузаантай, 20 см газарт суулгаж зугтгасан.



3. Техникийн тодорхойлолтонд: хашааны шонг 40 мм-ийн турбагаар хийж г  
40 см бетондож суулгах гэж заасан байсан.<sup>3</sup> Гүйцэтгэхдээ: хашааны шонг 40 м  
турбогаар хийж газарт 60 см бетондож суули





4. Хашааны торны нүхний радиус 8x8 см, торны төмрын голч 3 мм-ийн зузаантай техникийн тодорхойлолтонд заасан хэмжээгээр хийж гүйцэтгэсэн.





5. Техникийн тодорхойлолтонд: 70 см-ийн өргөнтэй явган хүний 2 ширхэг хаалга хийх  
Гүйцэтгэхдээ: 50x50 см-ийн хэмжээтэй квадрат төмрөөр 1м 80см-ийн өндөртэй 80 см-ийн  
өргөнтэй хаалганы араам хийж хаалгыг хийсэн.




6. Техникийн тодорхойлолтонд 12x12 хэмжээтэй сагсны талбайн бетон зутгана, 10  
см зузаантай зах нь налуу, стандарт зураасуудыг хийж талбайг будах Сагсны шийд 1ш  
стандартаар суулгана. /үйлдвэрийнх/

Гүйцэтгэхдээ: Сагсны талбайг 12x12 хэмжээтэй бетоныг 15 см-ийн зузаантай зутгаж,  
стандарт зураасуудыг хийж талбайг будсан үйлдвэрийн шийдэн самбартай сагсны




Техникийн тодорхойлогод: 8ш сандал 1.5 метрээс 2 метрийн урттай , түшлэгтэй газарлуу 30 см суулгаж зугтана.

Гүйцэтгэхдээ: Эх орны үйлдвэрийн гялгар цаасаар шахаж хийсэн бат бөх 1.5 метрийн урттай, 8ш түшлэгтэй сандалыг 30 см-ийн урттай шрүпээр бетон шаланд бэхэлж тогтоосон.



Нарны тольтой 4 ширхэг лед гэрлийг хашааны 4 буланд 4 метрын өндөр шон дээр байрлуулсан.





Элсэн талбайг 10x10 см дүнзийг 3 давхарлан хадаж, дүнзний газарт суух хэсгийг ус чийгнээс хамгаалах хар тосон түрхлэг түрхэж хийсэн. Элсэн талбайн дотор цэвэр зай 3x3 метртэй хийж цэвэр торгон элс асгасан.



Техникийн тодорхойлотонд: Сүүдрэвч 6 талд байх, 1 талын урт 1.6 метрээс багагүй байх мөн шалыг 5 см ээс багагүй бетон зутгах.

Гүйцэтгэхдээ: "Террас сүүдрэвч" үйлдвэрийн 1 талын урт 1.8 метртэй 6 талтай модон материалаар хийсэн сүүдрэвчийг угсарч зориулалтын дээврийн материалаар дээврийг хийж тосон будгаар будаж, шалыг 10 см зузаантай бетон зутгаж хийсэн.



Техникийн тодорхойлотонд: Явган хүний замын хавтанцарыг 5см зузаантай элсэн дэвсгэр дээр шахаж тавих бөгөөд 2 хажуугаар нь 15x10 см ийн бетон хашлага зутгана. Нийт 40м урттай

Гүйцэтгэхдээ: Явган хүний замыг 5 см-ийн зузаантай элсэн дэвсгэр дээр хүрээгээр нь 15x10 см ийн хэмжээтэй үйлдвэрийн бетон хашлага хийж, зориулалтын хавтангаар шахсан. Замын урт 40м өргөн- 1м 90см



Дүүжин даажин тоглоом-1 ширхэг



Гулсуурын олон төрөлт тоглоом-1 ширхэг



8 хүний даацтай үсэрдэг тоглоом-1 ширхэг,






6 хүүхдийн суудалтай эргэдэг тоглоом-1 ширхэг  
( 40м хашаа барих зардлаар нэмэлтээр авсан.)



Дасгалын төхөөрөмж-1 ширхэг  
(40м хашаа барих зардлаар нэмэлтээр авсан)<sup>15</sup>



Нэг талын 40 метр хашааг барилгүйгээр хөл бөмбөгийн талбайн нэг талын хашааг ашиглан хийсэн. Засаг даргын тамгын газартай зөвшилцөн 40 метрийн урттай хашааны үнээр зураг төсөвт заагдаагүй нэмэлт тоглоом, дасгалын төхөөрөмж, тоглоомын суурь, явган хүний 2 хаалганы араам зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

**Нэг талын 40 метр хашааны зардлын тооцоо:**

1. Угольник /40x40/- 130м\* 7000=910000
2. Трубо /40x40/-31.2м\*10000=312000
3. Полосса/40x40/-26м\*3000=78000
4. Тор /1.5x4/ 13ш\*70000=910000
5. Суурь бетоны цемент-10\*19000=190000

Нийт дүн-2.400.000

**Нэмэлтээр авсан тоглоом, хийсэн ажлын зардлын тооцоо**

1. Зургаан хүүхдийн суудалтай эргэдэг тоглоом-1ш\* 1500.000=1500.000
2. Дасгалын төхөөрөмж-1ш\*600.000=600.000
3. Нийт 6 ширхэг тоглоомыг суурилуулах бетонд  
- цемент 6 уут\*19000=114000
4. Хаалганы араамны квадрат /50x50/ 12,4 м\*13000=161200

Нийт дүн-2.375.200

Уг ажлыг 2022 оны 11 дугаар сарын 16-ны өдөр эхэлж, 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр ашиглалтад оруулж хүлээлгэж өгсөн.

ТАЙЛАН БИЧСЭН:

ТҮРҮҮ АЛТАН ЖОЛОО ХХКБ. *Тухайн ахуй* Б АНХУУЛААР



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 1/41

Хатан суудал

Хүүхдийн тоглоомын талбай байгуулах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хийгдэх хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлын үйл явц, гүйцэтгэлд хяналт тавьж хүлээн авах ажлын хэсгийн доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Энхбат – Засаг даргын орлогч

Гишүүд: Г.Тунгалаг – Нягтлан бодогч

Ш.Хоролсүрэн – Санхүү албаны дарга

А.Гантулга – ЖДҮ хоршоо хариуцсан мэргэжилтэн

П.Норовсамбуу – Нярав

2. Ажлыг захиалагчтай байгуулсан гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн байдалд хяналт тавьж, нягтлан шалгаж холбогдох баримт бичгийг боловсруулан сумын Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх)-д даалгасугай.

ДАРГА  Г.МӨНХБАТ



642301032



## ХҮҮХДИЙН ТОГЛООМЫН ТАЛБАЙН АЖИЛ ХҮЛЭЭН АВСАН АКТ

2023 оны 05 дугаар сарын 12


Хатан суудал

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Хатан суудал 5-р багт хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлын тендер 2022 онд зарлан ТҮРҮҮ АЛТАН ЖОЛОО ХХК шалгаран гэрээ байгуулсан.


Хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажилд хяналт тавих, хүлээн авах ажлын хэсгийг Засаг даргын 2023 оны 03 дүгээр сарын 30-ний өдрийн А/41 дугаар захирамжаар томилсон. Ажлын хэсгийн ахлагч Ж.Энхбат (Засаг даргын орлогч), гишүүд Ш.Хоролсүрэн (Санхүү албаны дарга), П.Норовсамбуу (Нярав), А.Гантулга (ХХСангийн мэргэжилтэн) Г.Тунгалаг (Нягтлан бодогч) нар тоглоомын талбай байгуулах ажилд тухай бүр хяналт тавьж ажилласан.


Хашаа хийх ажил техникийн тодорхойлолтоор: 20х40 хэмжээтэй 2 метрийн өндөртэй, шон хоорондын зай 3м, төмөр хүрээтэй торон хашаа байх. Шонг 40мм-ээс доошгүй төмөр трубагаар хийж газарт 40см бетондож суулгана. явган хүний 2 хаалгатай , 70см өргөнтэй, торны нүхний радиус 8х8см ихгүй голч нь 3мм-ээс нарийнгүй , хашааг хар өнгийн тосон будгаар будна.


Гүйцэтгэл: 20х40 хэмжээтэй 3 тал хашааг 2 метрийн өндөртэй шон хоорондын зай 3м ,60см төмөр хүрээтэй торон хашаа хийсэн, шонг 40мм-с доошгүй голчтой төмөр трубагаар хийж газарт 60см бетондож суулгасан, явган хүний 2 хаалгатай ,хаалга нь 95см өргөнтэй, торны нүхний радиус 8х8, голч нь 3мм , хашааг хар өнгийн тосон будгаар будсан.















### Хөл бөмбөгийн талбайн

техникийн тодорхойлолтоор: 12x12 хэмжээтэй сагсны талбайн бетон зутгана. 10см зузаантай зах нь налуу стандарт зураасуудыг хийж талбайг будах.

Гүйцэтгэл: 12x12 хэмжээтэй сагсны талбайн 10см зузаантай бетон зутгаж хийсэн, зах тэгш, сагсны шийд 1ш, стандарт зураасуудыг хийж талбайг будсан






Сандал  
техникийн тодорхойлолтоор: 8ш сандал 1.5 метрээс 2м -ийн урттай, түшлэгтэй  
газар луу 30см суулгаж зутгана.




Гүйцэтгэл: эх орны үйлдвэрийн 1.5м урттай зөөврийн 8ш сандлыг байршуулсан байна.



#### Хогийн сав

Техникийн тодорхойлолтоор: өргөн нь 30х30, өндөр 80см

Гүйцэтгэл: 40х40 өргөн, 85см өндөр 3 ш зөөврийн хогийн сав байршуулсан.





## Нарны толь


Техникийн тодорхойлолтоор: 4ш нарны тольтой нараар ажилдаг лед гэрэл, шонтойгоо ком 4м-ийн өндөр шонтой байх.


Гүйцэтгэл: нараар ажилдаг удирдалгатай 4ш лед гэрэл 4м-ийн өнөр шонтой



Техникийн тодорхойлолтоор: : Хашааны суурь бетон 20см өргөн, 30см зузаантай 20 см газарт суулгаж зугтана

Гүйцэтгэл: Хашааны суурь бетон 25см өргөн, 30см зузаантай 20 см газарт суулгаж зуггасан байна.







### Элсэн талбай

Техникийн тодорхойлолтоор: Элсэн талбайг 10x10см дүнгээр 3 давхарлан хашлага хийнэ. Дүнгний газарт суух хэсэг болон элс хийх хэмжээнд ус чийгнээс хамгаалах хар тосон түрхлэг түрхэнэ.

Гүйцэтгэл: 3.55x 3.55 харьцаатай элсэн талбай нь 15см өргөн дүнгээр 3 давхар хашлагтай, дүнгний газарт суух хэсэг болон элс хийх хэмжээнд ус чийгнээс хамгаалах хар тосон түрхлэг түрхсэн.









### Явган зам

Техникийн тодорхойлолтоор: Явган хүний замын хавтанцарыг 5см зузаантай элсэн дэвсгэр дээр шахаж тавих бөгөөд 2 хажуугаар нь 15x10см -ийн бетон хашлага зутгана. Нийт 40м урттай

Гүйцэтгэл: 180 өргөнтэй, 40 метрийн урттай явган хүний замын хавтанцрыг 5см зузаантай элсэн дэвсгэр дээр шахаж, 2 хажуугаар нь 20x8см-ийн харьцаатай бетон хашлага суулгаж хийсэн.





### Сүүдрэвч

Техникийн тодорхойлолтоор: 6 тал байх , 1 талын урт 1.6 м-ээс багагүй байх мөн шалыг 5см-ээс багагүй бетон зутгана.

Гүйцэтгэл: Сүүдрэвч нь 6 талтай нэг талын урт нь 1.95см , 5см бетон шалтай хийсэн. Сүүдрэвчний дээврийг хадаасаар давхар бэхэлж өгсөн нь илүү найдвартай бат бөх болсон байна.





Олон үйлдэлт гулсууран тоглоом 1ш, суурийг бетон зутгаж хийсэн






Хос суудалт савлуур 1ш





Үсэрдэг тоглоом 1ш







Дүүжин дажин





Эдгээр ажлуудыг техникийн тодорхойлолтын дагуу хийж гүйцэтгэх явцад хөл бөмбөгийн талбайн хэсгийн 40м хайсны оронд нэмэлтээр 2 ш хүүхдийн тоглоомыг нэмж суурилуулсан байна.



Ажлын хэсэг 2023 оны 05 сарын 25ны өдөр хуралдаж хийгдээгүй 40 м хашааны төсвийг зураг төсвийн зардлын задаргааны дагуу нийт 2396725 төгрөгөөр тооцож, нэмэлтээр суурьлуусан 2 ш хүүхдийн тоглоом нийт 2.100.000 төгрөг, ажлын зардал зэргийг тооцон нийт 2375200 төгрөг гэж үзэн зөрүү 21500 төгрөгийг суутгаж үлдэгдэл санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсэн.



# Буман Тоглоомын Дэлгүүр



11

6000000

台式双人漫步机  
规格: 1900\*1100\*800mm



# Буман Тоглоомын Дэлгүүр

1500000

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Энхбат

гишүүд:

Ш.Хоролсүрэн

П.Норовсамбуу

Т.Тунгалаг

А.Гантулага

